

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд олон улсын хувийн хэвшлийн
байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт
2017 оны 9-р сарын 1

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org у-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 9-р сарын 1-нд олон улсын хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p>Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</p>	<p>1. Уул уурхайн салбар бол тэргүүлэх салбар – Уулзалтын бүх оролцогчид Монгол Улсын хөгжилд уул уурхайн салбар чухал болохыг онцолж байв.</p> <ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбар нь Монголыг аж үйлдвэрийн тэргүүлэх улс болоход түлхэц үзүүлэх бололцоотой • Засгийн газар маш олон зүйл хийхийг хүсч байгаа хэдий ч бодит амьдрал дээр аль салбарын үйл ажиллагаа явж байна гэдгийг харж, үүн дээр төвлөрөх хэрэгтэй. Энэ утгаараа эрдэс баялгийн салбар Монголыг эргээд хөгжлийн замд авчирч чадна • Засгийн газрын зүгээс уг салбарыг дэмжихийн тулд дэлхийн хэмжээний компаниудыг оруулж ирж, тэдний хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай итгэлийг өгөхийн тулд шударга хууль, дүрмийг боловсруулах хэрэгтэй
	<p>2. Тогтвортой байдал, хэрэгжилт болон бодлого, хууль тогтоомжийг тодорхой ил тод байлгах</p> <ul style="list-style-type: none"> • Уул уурхай, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд Засгийн газрын урт хугацааны бодлого төлөвлөлт чухал бөгөөд үүнийг хөгжүүлэх шаардлагатай. Бодлого боловсруулах явц богино хугацааны ашиг сонирхол, улс төрийн сэдлээс хамааралтай байна.

	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулагч нарт тулгарч буй хамгийн том сорилт бол хууль эрх зүйн орчны тогтвортой байдал болон улс төрийн эрсдэл • Хөрөнгө оруулагч нарыг татахын тулд хуулийн хэрэгжилтийг сайжруулж, байгаа хуулиудаа илүү оновчтой болгон сайжруулах хэрэгтэй • Хуулийн төслийг боловсруулах явцад Засгийн газар оролцогч талуудтай хангалттай сайн зөвлөлдөж, тухайн хуулийн төслийг хэрэгжхээс өмнө туршдаггүй тул батлагдсан хууль тогтоомж хэрэгжих боломжгүй эсвэл бизнесийн байгууллагуудад сөрөг нөлөөтэй байх нь элбэг. Жишээ нь, банкны тухай, уул уурхайн салбарын орлогын тухай, гадаад ажиллах хүчний тухай зэрэг хуулиуд • Гэрээний хэрэгжилтийг хангах, дампуурлын тухай хуулийн зохицуулалт сул. Гэрээний төлбөр хийгдэхгүй байх асуудлууд дээр олон компаниуд бэрхшээлтэй тулгардаг • Гадаадын хөрөнгө оруулагчид мэдээллийг олж авах тал дээр саад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд бодлого, дүрэм журмын талаар тодорхой, хэрэгцээтэй мэдээлэл олгодог төвлөрсөн газар, эх сурвалжтай болох шаардлагатай
	<p>3. Засгийн газрын чадавх, засаглал болон хариуцлагын тогтолцоо</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газрын тэргүүлэх зорилтууд хувийн хэвшлийн зорилтуудаас зөрүүтэй байх нь элбэг байдаг. Энэ нь жишээ нь хувийн хэвшил уул уурхайн салбарыг тэргүүлэх салбар гэж харж байхад Монгол Улсад уул уурхайн бизнес хийх хамгийн тааламжгүй орнуудын нэг байсаар байна • Засгийн газрын чадавхийг бэхжүүлж, чадвартай төрийн албыг хөгжүүлэх шаардлагатай • Өнөөдөр яригдаж байгаа асуудлууд өнгөрсөн 20 жилийн хугацаанд яригдаж байсан асуудлууд бөгөөд үр дүн муутай, улс төрчид өөрсдийн хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн, гадны зөвлөмжийг анхаардаггүй нөхцөл байдалтай байна. Олон улсын санхүүгийн байгууллагууд Засгийн газарт үргэлжлүүлэн дэмжлэг туслалцаа үзүүлэх бол тэд хариуцлагын тогтолцоог бий болгох хэрэгтэй.
	<p>4. Эдийн засгийг төрөлжүүлэх – уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуйн салбар Монголд цаашид хөгжих боломж бололцоо сайн байна – ХААн салбар харьцангуй их ажлын байрыг бий болгодог, байгаль орчинд ээлтэй бөгөөд Хятад хэмээх томоохон зах зээл сонирхож байгаа. • ХААн салбар цаг уурын нөхцлөөс их хамааралтай байдгийг бууруулах үүднээс усжуулалтын стратегийн төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай • Аялал жуулчлал бас нэг тэргүүлэх салбар болон хөгжих боломжтой. Азийн жуулчид маш ихээр сонирхдог, өвөл зуны аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгтэй • Бүс, зам зэрэг бүс нутгийн санаачлагуудтай уялдаатайгаар бусад салбаруудыг хөгжүүлэх олон боломж бололцоо байна

5. Хувийн хэвшлийн хөгжил

- Улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэл бол чадамжтай хувийн хэвшилд тулгуурлан чөлөөт зах зээлтэй эдийн засгийг хөгжүүлэх юм. Өнгөрсөн хэдэн жил төрөөс удирдан чиглүүлж, хэрэгжүүлж ирсэн төслүүд цаашаа явахгүй гэдгийг харуулсан. Хувийн хэвшил ажлын байрыг бий болгодог.
- Хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого хэрэгтэй, нэн ялангуяа төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд. Төр-хувийн хэвшлийн тухай хууль тогтоомж илүү ойлгомжтой, боловсронгуй болгох шаардлагатай.
- Монголын өрсөлдөх чадварыг сайжруулж, дэлхийн тэргүүлэх компаниудыг татахын тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хамгаалж, цаашид үргэлжлүүлэн дэмжих хэрэгтэй.
- Улс төрийн эрсдэл өндөр байдаг нь хөрөнгө оруулагч нарт өндөр ашиг олох хүлээлт үүсгэдэг.

6. Дэд бүтцийн хөгжил

- Уул уурхайн салбарыг хөгжүүлэх бол дэд бүтцийн хөгжил чухал ач холбогдолтой. Уурхайнуудыг хөрш орнуудтай холбох зам тээвэр, төмөр зам нь Монголын өрсөлдөх чадварыг хадгалахад нэн шаардлагатай.
- Дэд бүтцийн төслүүдийг хөгжүүлэхэд тогтвортой, урт хугацааны стратеги, төлөвлөлт хэрэгтэй.
- Нүүрсний салбар тэлж байгаа боловч одоо байгуу замууд чанар, даацын хувьд тогтвортой биш.
- Арилжааны банк/аж ахуйн нэгжүүд томоохон дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэхэд санхүүжилт олгох, Засгийн газартай яриа хэлэлцээр хийх тал дээр хүндрэлтэй байдаг. Иймд олон улсын санхүүгийн байгууллагууд талуудын уялдаа холбоог хангах, төслүүдийг боловсруулахад тэргүүлэх үүрэгтэй оролцох хэрэгтэй.

7. Олон нийтийн боловсрол болон сурталчилгаа

- Сонгогчдын дундах иргэний боловсрол, ойлголт муу байгаа нь одоогийн улс төр, эдийн засгийн асуудлуудад хүргэхэд нөлөөлсөн
- Мега төслүүд болон томоохон уул уурхай, дэд бүтцийн төслүүдэд улс төрийн нөлөө их байдаг бөгөөд улс төрчид харин олон нийтийн санал бодолд мэдрэг байдаг. Тиймээс олон нийтийн мэдлэг мэдээлэл, боловсрол, дуу хоолойг нэмэгдүүлэх нь зөв бодлогыг гаргаж ирэхэд чухал үүрэгтэй.
- Холбоод, ТББ-ууд болон олон улсын санхүүгийн байгууллагууд зөв мэдээлэл, мессежийг олон нийтэд хүргэж, чухал шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх үйл ажиллагаа, сурталчилгааг хийхэд хамтран ажиллах хэрэгтэй.
- ДБГ-ын судалгаа, дүн шинжилгээний чанар, ач холбогдол өндөр байдаг тул тэдгээрийг илүү өргөн хүрээнд түгээх, илүү их ашиглах тал дээр анхаарах хэрэгтэй. Хөгжлийн зарим байгууллагуудын өмнө хийсэн олон

	<p>нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлууд үр дүн муутай байсан ба үр дүн, хийх арга барилдаа анхаарал тавих хэрэгтэй. Жишээ нь сошиал сүлжээ болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулах тайлан, судалгааны ажлуудыг илүү өргөн хүрээнд түгээх.</p> <p>8. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн зах зээл хөгжөөгүй байгаа нь хувийн хэвшлийн өсөх боломж, нөөцийг хааж байна. • Хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулах сонирхолтой боловч гарах боломж хомс байгаа нь асуудал болж байна. • Санхүүжилт өндөр эрэлт хэрэгцээтэй байна. <p>9. Бусад асуудлууд:</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн сургалт, боловсролыг хөгжүүлэхэд илүү их анхаарах хэрэгтэй. Уул уурхайн салбарт нарийн мэргэжлийн биш, залуучуудыг хурдан сургаад авах боломжтой ажил зөндөө байдаг. • Бүс нутгийн холбоо, шүтэлцээ болон хил гаалийн хамтын ажиллагааны санаачилгуудыг дэмжих хэрэгтэй. • БНХАУ-ын хөрөнгө оруулалтын эсрэг байдаг нь Хятад хөрөнгө оруулагч нарыг хөрөнгө оруулахаас зайлсхийхэд хүргэдэг. Засгийн газар бодлогоо илүү нээлттэй, тууштай байлгах шаардлагатай. • Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудад анхаарал хандуулах хэрэгтэй, тур дундаа усны менежментийн асуудалд. • Хот, суурин газрын хогны менежментийн асуудал нэмэгдэж байна. • Агаарын бохирдлын асуудалд Засгийн газраас шийдэл олоогүй, маш их хурц асуудал болж байна.
<p>ДБГ-ын түншлэл, стратегийн талаарх санал зөвлөмж</p>	<p>Арга барил, хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулахдаа илүү оновчтой, ач холбогдолтой арга барилаар ажиллах, жишээ нь сошиал медиаг хэрэглэх.
<p>ДБГ-ын оролцоо, хамтын ажиллагааны талаарх санал зөвлөмж</p>	<p>Potential areas of engagement:</p> <ul style="list-style-type: none"> • Оролцогч талуудаас хамгийн их дэвшүүлсэн санал нь Засгийн газарт зөв бодлого боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх гэсэн санал байв. • Эдийн засгийн хувьд ач холбогдол бүхий дэд бүтцийн томоохон төслүүдийн эрсдэл, үр ашгийн талаар олон нийт болон улс төрчдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн кампанит ажил, хөтөлбөрүүдийг явуулах.

	<ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшил, Засгийн газрын хооронд зохицуулагч маягаар гүүр болох, бодит асуудал болон тэдгээрийн шийдлүүдийг хэлэлцэх хэлэлцүүлэг, чуулга уулзалтуудыг зохион байгуулах. • Олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжийн төслүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх. • Хувийн хэвшлийн холбоодтой хамтран улс орны хөгжилд чухал ач холбогдолтой асуудлууд дээр олон нийтийн мэдлэг, боловсролыг сайжруулах. • Томоохон төслүүд дээр олон талуудын уялдаа холбоог хангах, төслүүдийг зөв боловсруулахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэх. • Бизнес хийх зардлыг багасгахын тулд бага өртөгтэй санхүүжилт эсвэл баталгааг гаргах • Уул уурхайн бус салбарын нөөц боломж, бололцоог нээхийн тулд зах зээлийн судалгаа хийх. • Ур чадвартай, мэргэжлийн төрийн албан хаагчдыг бэлтгэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх. • Орлогын тэгш бус байдал нэмэгдэж байгааг шийдэхийн тулд нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд засгийн газарт дэмжлэг үзүүлэх. • Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжихийн тулд хөрөнгийн биржийн хөгжил, хувьчлалын талаар зөвлөмж, зөвлөгөө өгөх.
--	---

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

Боломжит хариулт	Оролцогчдын хариулт
– Төрийн удирдлага/шинэтгэл	71.43% 10
– Хувийн хэвшлийг хөгжүүлэх	57.14% 8
– Боловсрол	50.00% 7
– Гадаадын хөрөнгө оруулалт	42.86% 6
– Авлигатай тэмцэх	35.71% 5
– Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	35.71% 5
Байгалийн нөөцийн удирдлага	28.57% 4
– Эдийн засгийн өсөлт	28.57% 4

Боломжит хариулт	Оролцогчдын хариулт
– Бусад	21.43% 3
– Зам, тээвэр	14.29% 2
– Эрчим хүч	14.29% 2
– Санхүүгийн зах зээл	14.29% 2
– Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	14.29% 2
– Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	14.29% 2
– Хүнсний аюулгүй байдал	7.14% 1
– Хөдөөгийн хөгжил	7.14% 1
– Хотын хөгжил	7.14% 1
– Худалдаа, экспорт	7.14% 1
– Эрх тэгш боломжоор хангах	0.00% 0
– Нийгмийн хамгаалал	0.00% 0
– Гамшгийн эрсдэлийн удирдлага	0.00% 0
– Ус, ариун цэврийн байгууламж	0.00% 0
– Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	0.00% 0
– Эрүүл мэнд	0.00% 0

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Боломжит хариулт	Оролцогчдын хариулт
– Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	50.00% 7
– Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	50.00% 7
–	50.00%

Боломжит хариулт**Оролцогчдын хариулт**

Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	7
– Хүний хөгжлийг дэмжих	35.71% 5
– Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	35.71% 5
– Бүгд чухал	14.29% 2